Бэлчээр зохион байгуулалтын арга хэмжээг бэлчээр ашиглагчдын хэсэг, баг, сумын түвшинд судлах, төлөвлөх, хэрэгжүүлэх, олон талын оролцоог хангах талаар оорийн үзэл баримтлалын хүрээнд боловсруулсан арга зүйн зөвломжийг байнга баяжуулан ашиглаж байна. Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд бэлчээрийн асуудлыг боловсруулж тусгах арга зүйн зөвломжийг боловсруулсан. Төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад нэлээд хэмжээний тоон мэдээлэлд анализ хийх шаардлагатай болдог ба бэлчээрийн хувьсан өөрчлөлт доройтол түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодорхойлон учир шалтгааныг илрүүлэхэд олон талын цогц судалгаа хийх шаардлагтай байдаг.

Манай улсын хэмжээнд хэд хэдэн байгууллага оорийн гэсэн онцлогтой, давуу талтай програм боловсруулан төлөвлөлтөд ашиглаж байгаа боловч эдгээр нь хоорондоо хорвох мэдээлэл солилцох талаар хангалтгүй байгаа юм.

Тус програмыг сумын хэмжээнд бэлчээр зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад шаардагдах тоон мэдээллийн сан бүрдүүлэх, түүнд боловсруулалт, дүн шинжилгээ хийх зэргээр орон нутгийн төрийн болон хогжлийг дэмжих зорилгоор үйл ажиллагаа эрхэлж буй дурын этгээд ашиглахаар бүтээсэн

**Тус програм нь дараах давуу талтай**

- Ажил хонговчилж цаг хэмнэх.
- Олон дахин давтан бичигддэг мэдээллийг дахин бичихгүйгээр сонголтоор болон автоматаар авах.
- Томъёогоор бодох бодолтыг автоматаар хийх.
- Үр дүнг хүссэн хэлбэрээр буюу аймаг, сум, бэлчээрийн ангилал, нэгж талбар, нийтийн бэлчээр, хот айл тус бүрээр ялгаж гаргах.
- Мэдээллүүдийг цэгцтэй загварт оруулах.
- Энгийн богоод ойлгомжтой болгох.
- Мэдээллүүдийг эмх цэгцтэй хадгалж, ашиглах.
- Мэдээллүүдийг мэдээллийн сангийн бусад програмтай холбоход дохомтэй болгох.

- Мэдээллийн аль ч огогдлоор сум, аймаг, улсын түвшинд анализ хийх.

**Програм татах**

{pdf}images/pdfbook/3/+GG2.0 Zaavar.pdf{/pdf}